



## САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 29 өдөр

Дугаар 36

Улаанбаатар хот

### Даатгалын компанийн бүтээгдэхүүнийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.1, 6.2.3, Даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.6, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралт “Даатгалын, даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг авах хүсэлт гаргахад бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт болон даатгагч, даатгалын мэргэжлийн оролцогчид тавигдах шаардлага, дагаж мөрдөх үзүүлэлт”-ийн 4.7.10 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Миг даатгал” ХХК-ийн “Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал”-ын бүтээгдэхүүнийг нэгдүгээр хавсралтаар, “Гадаад ачаа тээврийн даатгал”-ын бүтээгдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус бүртгэсүгэй.

2. Даатгалын бүтээгдэхүүнийг бүртгэсэнтэй холбогдуулан Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 02 дугаар тогтоолоор баталсан “Даатгалын багц дүрэм”-ийн 01 дүгээр хавсралтын 4.7.1-д “... Бүртгүүлсэн даатгалын бүтээгдэхүүний нөхцөл шаардлага бүхий загвараар тухайн бүтээгдэхүүнийг зах зээлд борлуулна” гэж заасныг мөрдөж ажиллахыг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын 1-д заасан бүтээгдэхүүний гэрээнд худал, хуурамч, дутуу, төөрөгдүүлсэн, алдаатай заалт, мэдээлэл тусгасны улмаас даатгуулагчид хохирол учруулсан тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэхийг “Миг даатгал” ХХК /Б.Мөнххишиг/-д анхааруулсугай.

4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.


ДАРГА  Д.БАЯРСАЙХАН



F:\ajil 2020\hural\huulbar unen\togtool.docx

151000000070


Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 2 дугаар сарын 29 өдрийн  
36-р тогтоолын нэгдүгээр хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Миг даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Тээвэрлэгчийн хариуцлагын даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Хариуцлагын даатгал
4.	Даатгалын зүйл	Тээвэрлэж байгаа ачаа барааны өмчлөгч, эзэмшигчийн өмнө хүлээх даатгуулагчийн хариуцлага
5.	Даатгалын эрсдэл	<ul style="list-style-type: none"><li>• Зам тээврийн осол</li><li>• Ачаа барааг ачих, буулгах үеийн тээвэрлэгчийн буруутай үйл ажиллагаанаас гарсан гэнэтийн осол</li></ul>
6.	Даатгалын гэрээний хугацаа	<ul style="list-style-type: none"><li>• Гэрээний хугацааг тусгайлан заагаагүй бол 14 хоног</li><li>• Ачаа барааг илгээгчээс хүлээн авагчийн заасан газарт өгөх хүртэл хугацаа</li></ul>
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 98 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 15-н өдрийн А-19-830 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ч.Баттүшиг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгал хариуцсан дэд захирал Д.Долгор, андеррайтер Б.Хатанбүүвэй

Санхүүгийн зохицуулах хорооны  
2019 оны 01 дугаар сарын 29 өдрийн  
36-р тогтоолын хоёрдугаар хавсралт



Даатгалын бүтээгдэхүүний мэдээлэл

1.	Даатгалын компанийн нэр:	“Миг даатгал” ХХК
2.	Даатгалын бүтээгдэхүүний нэр:	Гадаад ачаа тээврийн даатгал
3.	Хамаарах даатгалын хэлбэр:	Ачаа тээврийн даатгал
4.	Даатгалын зүйл	Монгол улсаас гадаад орнуудад, гадаад орнуудаас Монгол улсад, Монгол улсын нутаг дэвсгэр дээгүүр дамжин өнгөрч буй болон гадаад орнуудын нутаг дэвсгэр дээгүүр тээвэрлэгдэж буй ачаа бараа
5.	Даатгалын эрсдэл	<p>INCOTERMS 2010-A нөхцөл</p> <ul style="list-style-type: none"><li>Гэрээний хасалт хэсэгт зааснаас бусад Бүх эрсдэл</li></ul> <p>INCOTERMS 2010-B нөхцөл</p> <ul style="list-style-type: none"><li>Гал түймэр, дэлбэрэлт, аянга цахилгаан</li><li>Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, аянга цахилгаан</li><li>Тээврийн хэрэгсэл хөмрөх, онхолдох, төмөр замаас гарах</li><li>Тээврийн хэрэгсэл хоорондоо эсвэл үл хөдлөх биет, хөвөгч юмсыг мөргөх, гүүрний нуралт</li><li>Аюул учирсан үед ачааг портоос шилжүүлэх явцад гарах хохирол</li><li>Хөлөг онгоц усанд живэх, шидэгдэх, хөлөг онгоц болон нисдэг тэрэг сураггүй алга болох</li><li>Ерөнхий дундаж</li><li>Ачааг хаях</li><li>Хөлөг онгоц, чингэлэг, галт тэрэг, агуулахад далай, нуур, голын ус нэвтрэн орох</li><li>Ачааг ачиж буулгах болон тээврийн хэрэгсэл дээр байх үеийн аливаа осол гэмтэл</li></ul> <p>INCOTERMS 2010-C нөхцөл</p> <ul style="list-style-type: none"><li>Гал түймэр, дэлбэрэлт, аянга цахилгаан</li><li>Газар хөдлөлт, галт уулын дэлбэрэлт, аянга цахилгаан</li><li>Тээврийн хэрэгсэл хөмрөх, онхолдох, төмөр замаас гарах</li><li>Тээврийн хэрэгсэл хоорондоо эсвэл үл хөдлөх биет, хөвөгч юмсыг мөргөх, гүүрний нуралт</li><li>Аюул учирсан үед ачааг портоос шилжүүлэх явцад гарах хохирол</li><li>Хөлөг онгоц усанд живэх, шидэгдэх, хөлөг онгоц болон нисдэг тэрэг сураггүй алга болох</li></ul>



6.	Даатгалын гэрээний хугацаа	Илгээгчээс ачааг тээвэрлэгчид шилжүүлэн өгсөн үеэс тээвэрлэгч ачааг хүлээн авагчид хүлээлгэн өгөх хүртэл байна. Даатгалын баталгаанд өөрөөр заагаагүй бол тухайн даатгалын дээд хугацаа 90 хоног байна.
7.	Даатгалын гэрээний нийт бүлэг, заалтын тоо	11 бүлэг, 140 заалт
8.	Даатгалын бүтээгдэхүүн бүртгүүлэх тухай эрх бүхий албан тушаалтны шийдвэр:	Гүйцэтгэх захирлын 2019 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А-19-795 тоот тушаал
9.	Даатгалын хураамжийг тооцоолсон актуарч:	Ч.Баттүшиг
10.	Даатгалын гэрээ, нөхцөл боловсруулсан:	Даатгал хариуцсан дэд захирал Д.Долгор, андеррайтер Э.Мөнхтөр